

БАРИЛГЫН ХОГ ХАЯГДАЛД СУУРИЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТЫГ СУДЛАХ СУДАЛГАА

KAP SURVEY





КАРИТАС ЧЕХ РЕПАБЛИК ТББ

Делта төв, 5 давхар, 503 тоот, 1-р хороо
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот
Утас: 976-7013 5899

Имэйл: ccr.mongolia.office@caritas.cz

Веб сайт: <https://mongolia.charita.cz>



ЭМ ЭМ СИ ЖИ ХХК

Зүүн Хүрээ хотхон, 203-р байр, 4 давхар, 14-р хороо
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот,
Монгол Улс

Утас/Факс: 976-77000188

Имэйл: info@mmcg.mn

Вэб сайт: <http://www.mmcg.mn>

ESOMAR^{'19}
| corporate



Энэхүү тайланг Каритас Чех Републик болон хамтрагч байгууллагуудын хэрэгжүүлж буй "Монгол Улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих" төслийн хүрээнд боловсруулан гаргав. Тайланд орсон агуулга нь Европын Холбооны байр суурийг илэрхийлээгүй болно.

• • • АГУУЛГА

1. Төслийн ерөнхий танилцуулга, судалгааны арга аргачлал	8
1.1 Төслийн ерөнхий танилцуулга	8
1.2 Судалгааны арга зүй	8
1.3 Судалгааны аргачлал	9
2. Судалгааны хураангуй үр дүн	13
3. Судалгааны үр дүн	17
3.1 Мэдлэг мэдээлэл	17
3.2 Хандлага зуршил	23
3.3 Мэдээллийн хэрэгцээ	30
3.4 Мэдээллийн хэрэгслийн хэрэглээ	32
4. Дүгнэлт	38

● ● ● ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Түүврийн хэмжээ	9
Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан иргэд /Нас, дүүргээр/	10
Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын түүвэр	10
Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан барилгын материал үйлдвэрлэгч ААН байгууллагын ангилал	11
Хүснэгт 5. Ганцаарчилсан ярилцлагын түүврийн хэмжээ	12

● ● ● ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Судалгаанд хамрагдсан иргэдийн ажил эрхлэлтийн байдал	10
График 2. Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын судалгаанд хамрагдсан ажилтны албан тушаал	11
График 3. Барилгын материал үйлдвэрлэгч ААН байгууллагын судалгаанд хамрагдсан ажилтны албан тушаал	12
График 4. Барилгын салбар дахь нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих төслийн талаар сонсож байсан эсэх /Иргэн, ААН-ийн төрлөөр/	17
График 5. Монгол Улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих төслийн талаарх мэдлэг /Иргэн, ААН-ийн төрлөөр/	18
График 6. Барилгын салбарын хог хаягдлын талаарх хандлага /Иргэн, ААН-ийн төрлөөр/	19
График 7. Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах, ашиглах талаарх сургалт зохион байгуулагдаж байсан эсэх /ААН-ийн төрлөөр/	23
График 8. Барилгын хог хаягдлыг газарт булж байгаа талаарх нийтийн хандлага /Иргэд, ААН-ийн төрлөөр/	23
График 9. Барилгын дахин ашиглах боломжтой хог хаягдлыг булахыг хориглох хэрэгтэй эсэх /Иргэд, ААН-ийн төрлөөр/	24
График 10. Барилгын хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах байдлыг нэмэгдүүлэх хэрэгцээ /Иргэд, ААН-ийн төрлөөр/	24
График 11. Монголд хог хаягдлыг устгах систем хангалтгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж буй талаарх хандлага /Иргэд, ААН-ийн төрлөөр/	25
График 12. Барилгын хог хаягдлын менежментэд олон нийтийн анхаарал хяналтыг нэмэгдүүлэх хэрэгтэй гэдэгтэй санал нийлж буй байдал /Иргэд, ААН-ийн төрлөөр/	25
График 13. Барилгын хог хаягдлын талаарх холбогдох хууль, дүрэм журмын хэрэгжилт хяналтыг сайжруулах талаар /Иргэд, ААН-ийн төрлөөр/	26
График 14. Барилгын салбарын ААНБ-ын барилгын хог хаягдал хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх мэдлэг мэдээлэл хангалтгүй эсэх /Иргэд, ААН-ийн төрлөөр/	26
График 15. Барилгын компани, туслан гүйцэтгэгч болон дахин боловсруулалт хийдэг ААНБ-ын уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй эсэх /Иргэд, ААН-ийн төрлөөр/	27
График 16. Монгол улсад барилгын хог хаягдлыг дахин боловсруулдаг үйлдвэр ААН хангалттай байгаа гэдэгтэй санал нийлж буй эсэх /Иргэд, ААН-ийн төрлөөр/	27

● ● ● ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 17. Барилгын хатуу хог хаягдлыг булах төлбөрийг нэмэгдүүлснээр барилгын хог хаягдал буурна гэдэгтэй санал нийлж буй байдал	28
График 18. Барилгын дахин боловсруулсан материал нь дахин боловсруулаагүй материалтай харьцуулахад чанар нь ижил гэдэгтэй санал нийлж буй байдал /Иргэд, ААН-ийн төрлөөр/	28
График 19. Иргэдийн хандлага	29
График 20. Барилгын хог хаягдлын талаар барилгын салбар дахь жижиг дунд ААНБ-ын хандлага	29
График 21. Барилгын хог хаягдлын талаарх барилгын материал үйлдвэрлэгч ААНБ-ын хандлага	30
График 22. Барилгын хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүн болон барилгын хог хаягдлын менежментийн талаар мэдээллийн хэрэгцээ /Иргэн, ААН-ийн төрлөөр/	30
График 23. Барилгын хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүн болон барилгын хог хаягдлын менежментийн хэрэгцээтэй мэдээлэл /Иргэн, ААН-ийн төрлөөр/	31
График 24. Барилгын хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүн болон барилгын хог хаягдлын менежментийн талаар мэдээлэл авах сонирхол /Иргэн, ААН-ийн төрлөөр/	31
График 25. Ихэвчлэн үздэг телевизийн суваг	32
График 26. Телевизээс голчлон үздэг нэвтрүүлгийн төрөл	32
График 27. Телевиз үздэг тогтмол цаг болон үргэлжлэх хугацаа	33
График 28. Ихэвчлэн сонсдог FM радио	33
График 29. FM радиогоос сонсдог нэвтрүүлгийн төрөл	34
График 30. FM сонсдог тогтмол цаг болон үргэлжлэх хугацаа	34
График 31. Ихэвчлэн уншдаг, сонин сэтгүүл	35
График 32. Сонин сэтгүүлээс голчлон уншдаг мэдээний төрөл	35
График 33. Ихэвчлэн ашигладаг веб хуудас	36
График 34. Вебсайтаас уншдаг мэдээний төрөл	36
График 35. Ихэвчлэн ашигладаг социал хуудас	37
График 36. Социал сүлжээнээс уншдаг мэдээний төрөл	37

● ● ● ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ЖАГСААЛТ

Чанарын судалгааны үр дүнгээс 1:

Барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих төслийн талаар сонсож байсан эсэх 18

Чанарын судалгааны үр дүнгээс 2:

Барилгын хог хаягдлын байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн талаарх хандлага 20

Чанарын судалгааны үр дүнгээс 3:

Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах ажил хэрхэн явагддаг гэж үздэг тухай 20

Чанарын судалгааны үр дүнгээс 4:

Барилгын хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүний талаарх мэдлэг болон туршлага 21

Чанарын судалгааны үр дүнгээс 5:

Барилгын хог хаягдлыг устгах, ангилан ялгахад тулгардаг бэрхшээл 21

Чанарын судалгааны үр дүнгээс 6:

Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн талаар 22

Чанарын судалгааны үр дүнгээс 7:

Барилгын хог хаягдлын талаарх холбогдох хууль журам, тэдгээрийн хэрэгжилтийн тухай 22

● ● ● ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА

ТББ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

ЖДҮ ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ

МХП МЭДЛЭГ ХАНДЛАГА ПРАКТИК

БГД БАЯНГОЛ ДҮҮРЭГ

БЗД БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ

ЧД ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

ХУД ХАН УУЛ ДҮҮРЭГ

СБД СҮХБААТАР ДҮҮРЭГ

СХД СОНГИНО ХАЙРХАН ДҮҮРЭГ

CAPI COMPUTER-ASSISTED PERSONAL INTERVIEW /ТАБЛЕТ АШИГЛАН СУДАЛГАА АВАХ АРГА/

CSPRO CENSUS SURVEY PROCESSING SYSTEM /СУДАЛГААНЫ ӨГӨГДӨЛ ОРУУЛСАН ПРОГРАММ/

SPSS СУДАЛГААНЫ ӨГӨГДӨЛД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ПРОГРАММ

GPS GLOBAL POSITIONING SYSTEM /БАЙРШИЛ ТОГТООХ СИСТЕМ/



БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА, СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ

1.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Каритас Чех Републик ТББ нь Монголын Хог Хаягдлыг Дахин Боловсруулах Үндэсний Холбоо, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль болон Нидерландын Дельфтийн Технологийн их сургуультай хамтран “Монгол Улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих” төслийг Европын Холбоо, Чехийн Хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр хэрэгжүүлж байна.

Төслийн зорилго нь барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ эрхлэгчдэд нөөцийн үр ашигтай байдлыг болон цэвэр үйлдвэрлэл, хэрэглээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх замаар Монгол дахь ядуурал, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад хувь нэмэр оруулах явдал юм.

Барилгын салбар сүүлийн жилүүдэд хурдацтай өргөжин тэлж, барилгын бүх төрлийн бүтээгдэхүүний (бетон, металл г.м) хэрэгцээ жил ирэх тусам нэмэгдэж байгаатай холбоотойгоор импортын барааны эрэлт нэмэгдсээр байна. Барилгын салбар дахь судалгаа шинжилгээ, хөгжил, шинэчлэл, чанарын хяналт, журам, стандартын хөгжил дэвшил дутмаг байгаа нь барилгын бүтээгдэхүүн гаргах, барилгын хог хаягдлын менежментийг сайжруулахад саад учруулж байна.

Дээрх төслөөс хэрэгжүүлэх гол үр дүнгүүдийн нэг нь барилгын хог хаягдлыг дахин боловсруулж бүтээгдэхүүн гарган авах, ашиглах явдал юм.

1.2 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны зорилго

Судалгааны ажлын зорилго нь барилгын хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүний талаарх олон нийтийн ойлголт, мэдэгдэхүүнийг хэмжих, уг бүтээгдэхүүний давуу тал болон тус бүтээгдэхүүнийг сонирхож буй хэрэглэгчдийг илрүүлэхэд оршино. Судалгааны хүрээнд хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүний талаарх олон нийтийн болон бизнесийн ойлголтыг хэмжин судалж, барилгын салбар дахь хог хаягдлын менежментийн тогтвортой практик болон нөөцийн үр ашигтай байдлын талаарх ойлголтыг үнэлэх суурь судалгааг гаргах юм. Түүнчлэн барилгын хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүнийг сонирхож буй төрөл бүрийн бүлгийн хэрэглэгчдийн уг бүтээгдэхүүний талаарх мэдлэг, хандлагыг олж илрүүлэн, тодорхойлно. Судалгаа нь Мэдлэг, Хандлага, Практик (МХП) аргачлал буюу (KAP-knowledge, attitude, practice) аргыг ашиглан барилгын салбарын оролцогч талуудыг авч үзсэн болно.

1.3 СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Хийгдсэн судалгааны төрөл

1 ХУВЬ ХҮН БУЮУ ИРГЭДИЙН СУДАЛГАА

Иргэдийн судалгаагаар нийгэм, хүн ам зүйн мэдээлэл, иргэдийн ойлголт, мэдлэг, хандлага, барилга, барилгын материалын талаарх мэдээллийн эх сурвалж, хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүнийг цаашид сурталчлан таниулах арга хэрэгслийг тодорхойлно



2 БАРИЛГЫН САЛБАРЫН ЖИЖИГ, ДУНД ААНБ БОЛОН БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН СУДАЛГАА

Барилгын асуулгын хуудсаар нийгэм, хүн ам зүйн мэдээлэл, ААНБ ойлголт, мэдлэг, хандлага, барилга, барилгын материалын талаарх мэдээллийн эх сурвалж, хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүнийг цаашид сурталчлан таниулах арга хэрэгслийг тодорхойлно



3 БАРИЛГЫН САЛБАРЫН ТӨРИЙН БОЛОН ЖИЖИГ ДУНД ААНБ-ЫН ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГА СУДАЛГАА

Энэхүү аргын тусламжтайгаар тоон (КАР) судалгаагаар илрүүлэн гаргах боломжгүй чанарын мэдээллийг бүрдүүлэх ба асуудлыг илүү нарийн судалж, үр дүнд чанарын дүн шинжилгээ хийж судалгааны эцсийн тайланд оруулж өгнө.



САРИ Судалгааг тоон болон чанарын арга зүйд үндэслэн суурь мэдээллийг цуглуулсан болно.

Судалгаанд алдаагүй, үнэн зөв мэдээлэл цуглуулах, **түүнийг тухай бүрт нь хянах систем** буюу мэргэжлийн судалгааны **CsPro программын** тусламжтайгаар таблет /судалгааны дата цуглуулах ухаалаг төхөөрөмж/-ын тусламжтай цуглуулсан болно. Энэ программ нь мэдээлэл цуглуулалтын алдааг хамгийн бага байлгах арга зүйг нэвтрүүлсэн бөгөөд мэдээлэл цуглуулах, мэдээлэл оруулах бүх үйлдэл нэг дор, аль цэгээс судалгаа авсан **GPS байршлыг** тодорхойлох, **ярилцлагын аудио** бичлэг хийх, асуулгын логик уялдаатайгаар программчилсан нь **механик алдаа гарахгүй** байх, орчны зураг авах, **3G/4G** интернэт сүлжээ ашиглан өгөгдлийг цаг алдалгүй дамжуулах, судлаачдын **аюулгүй байдлыг бүрэн хангасан** зэрэг давуу талтай.



Судалгааны боловсруулалтыг нийгмийн судалгааны багц программ SPSS 25.0-ыг ашиглан хийсэн.

Түүврийн хэмжээ

Судалгааны ажлын хүрээнд Улаанбаатар хотын хэмжээнд 250 иргэнийг, барилгын салбарын 50 байгууллага мөн барилгын материал үйлдвэрлэгч 50 байгууллагыг түүврээр хамруулан мэдлэг, хандлага, туршлагын судалгааг гүйцэтгэсэн.

Хүснэгт 1. Түүврийн хэмжээ


Хамрах хүрээ	Зорилтот бүлэг	Түүврийн хэмжээ
Улаанбаатар хот	Иргэн	250
	Барилгын салбарын жижиг, дунд ААНБ	50
	Барилгын материал үйлдвэрлэгч ААНБ	50
Нийт		350

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан иргэд /Нас, дүүргээр/

ТҮҮВЭР	НАСНЫ БҮЛЭГ					Нийт	
	18-24 нас	25-34 нас	35-44 нас	45-55 нас	55-аас дээш		
Дүүрэг	БГД	6	15	10	10	4	45
	БЗД	9	19	11	10	6	55
	СХД	8	13	14	11	4	50
	СБД	7	9	12	8	4	40
	ХУД	4	12	5	6	3	30
	ЧД	3	10	6	7	4	30
	Нийт	37	78	58	52	25	250

Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 19 хувь нь хувиараа бизнес эрхлэгч, 14 хувь нь төрийн болон төсвийн байгууллагад ажилладаг байна.

График 1. Судалгаанд хамрагдсан иргэдийн ажил эрхлэлтийн байдал




Хүснэгт 3. Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын судалгаанд хамрагдсан түүвэр

АЖИЛТНЫ ТОО	ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ
10 хүртэлх ажилтантай	19
11-20 хүртэлх ажилтантай	14
21-50 хүртэлх ажилтантай	11
51-с дээш ажилтантай	6


Барилгын материал үйлдвэрлэгч ААНБ-ын хувьд доорх байдлаар түүвэрлэлтийг хийсэн бөгөөд тухайн ААНБ-ын удирдах түвшний албан тушаалтнаас судалгааг авсан болно.

График 2. Барилгын салбарын жижиг дунд ААНБ-ын судалгаанд хамрагдсан ажилтны албан тушаал



Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан барилгын материал үйлдвэрлэгч ААНБ-ын ангилал

БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛ	ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ
Арматур, төмөр хийцийн үйлдвэрлэл	10
Бетон, төмөр бетон эдлэлийн үйлдвэр	11
Бетон зуурмагийн үйлдвэр	10
Тоосго, блокын үйлдвэрлэл	5
Хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл	5
Бусад /дулаалгын материал үйлдвэр, хаалга цонхны үйлдвэр г.м /	9

График 3. Барилгын материал үйлдвэрлэгч ААНБ-ын судалгаанд хамрагдсан ажилтны албан тушаал

ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГА

Судалгаанд барилгын салбар дахь төрийн байгууллагын төлөөлөл болон бизнесийн байгууллагын төлөөллийг хамруулан нийт 10 удаагийн ганцаарчилсан ярилцлага зохион байгуулсан. Барилгын салбар дахь төрийн байгууллагын холбогдох албан тушаалтныг болон тухайн компанийн барилга болон төслийн, хяналтын инженерүүдийг энэхүү ганцаарчилсан судалгаанд мөн хамрууллаа.

Хүснэгт 5. Ганцаарчилсан ярилцлагын түүврийн хэмжээ

Хамрах хүрээ	Зорилтот бүлэг	Ярилцлагын тоо
Улаанбаатар хот	Барилгын салбарын төрийн байгууллагын төлөөлөл	5
	Барилгын салбарын жижиг, дунд ААНБ	5
Нийт		10

Энэхүү аргын тусламжтайгаар тоон судалгаа нь Мэдлэг, Хандлага, Практик (МХП) аргачлал буюу KAP (knowledge, attitude, practice) судалгаагаар илрүүлэн гаргах боломжгүй чанарын мэдээллийг бүрдүүлэх ба асуудлыг илүү нарийн судалж, үр дүнд чанарын дүн шинжилгээ хийж судалгааны эцсийн тайланд оруулсан болно. Ганцаарчилсан ярилцлагын тусгай удирдамжийн дагуу мэдээлэл цуглуулалтыг хийсэн.

БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ ҮР ДҮН

ҮЗҮҮЛЭЛТ	ХАРИУЛТ	ИРГЭН		БАРИЛГЫН ЖИЖИГ ДУНД ААНБ		БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭГЧ	
		ТОО	ХУВЬ	ТОО	ХУВЬ	ТОО	ХУВЬ
A1. Монгол Улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих төслийн талаар сонсож байсан уу?	Үгүй	214	86%	39	78%	40	80%
	Тийм	36	14%	11	22%	10	20%
A2. Монгол Улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих төслийн талаар хэр мэдлэгтэй вэ?	Огт мэдэхгүй	6	17%	0	0%	0	0%
	2	2	6%	1	9%	0	0%
	3	4	11%	4	36%	0	0%
	4	3	8%	1	9%	4	40%
	5	12	33%	1	9%	3	30%
	6	2	6%	2	18%	0	0%
	7	1	3%	0	0%	2	20%
	8	4	11%	1	9%	0	0%
	9	0	0%	0	0%	1	10%
	Маш сайн мэднэ	2	6%	1	9%	0	0%
A3.1. Барилгын салбарын хог хаягдлын хэмжээ сүүлийн жилүүдэд огцом нэмэгдэж байгаа.	Үгүй	9	4%	1	2%	7	14%
	Тийм	241	96%	49	98%	43	86%
A3.2. Барилгын хог хаягдал нь бусад төрлийн хог хаягдалтай харьцуулахад хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл багатай.	Үгүй	156	62%	12	24%	22	44%
	Тийм	94	38%	38	76%	28	56%
A3.3. Барилгын хог хаягдал нийт хатуу хог хаягдлын ¼ -ийг эзэлдэг.	Үгүй	45	18%	10	20%	12	24%
	Тийм	205	82%	40	80%	38	76%
A3.4. Барилгаас гарч буй хог хаягдлыг дахин ашиглах боломж өндөр байдаг.	Үгүй	67	27%	14	28%	9	18%
	Тийм	183	73%	36	72%	41	82%
A3.5. Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах, ангилах, ялгах ажил Монгол улсад хангалттай хийгддэггүй.	Үгүй	42	17%	6	12%	5	10%
	Тийм	208	83%	44	88%	45	90%
A3.6. /ААН-ээс асуух/ Хог хаягдлын тухай хууль, барилгын доторх хог хаягдлын менежмент стандарт, дүрэм журмуудын уялдаа холбоо хангалтгүй.	Үгүй	0	0%	15	30%	7	14%
	Тийм	0	0%	35	70%	43	86%
A3.7. Барилгын хог хаягдлын чиглэлээр хууль, стандартын хэрэгжилт, хяналт хангалтгүй байна.	Үгүй	8	3%	6	12%	7	14%
	Тийм	242	97%	44	88%	43	86%
A3.8. ААН-үүдийг барилгын хог хаягдлаа стандарт шаардлагын дагуу устгасан эсэхийг тухайн барилгыг хүлээн авахын өмнө нягталж шалгадаг болох.	Үгүй	5	2%	3	6%	1	2%
	Тийм	245	98%	47	94%	49	98%
A3.9. Барилгын хог хаягдлыг газарт булж устгах нь зөв.	Үгүй	177	71%	35	70%	35	70%
	Тийм	73	29%	15	30%	15	30%
A3.10. Барилгын хог хаягдлыг дахин боловсруулдаг үйлдвэр байдаггүй.	Үгүй	32	13%	9	18%	8	16%
	Тийм	218	87%	41	82%	42	84%
A3.11. Би ЗР буюу хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулахыг дэмжих талаар сонсож байсан.	Үгүй	201	80%	36	72%	28	56%
	Тийм	49	20%	14	28%	22	44%
A3.12. Барилгын ямар төрлийн хог хаягдал нь дахин ашиглагдах боломжтой талаар мэднэ.	Үгүй	114	46%	10	20%	13	26%
	Тийм	136	54%	40	80%	37	74%
A3.13. Барилгын хог хаягдлыг дахин боловсруулдаг ААНБ-уудын талаар мэднэ.	Үгүй	221	88%	37	74%	44	88%
	Тийм	29	12%	13	26%	6	12%
A3.14. Барилгын хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүний чанарт эргэлздэг.	Үгүй	109	44%	22	44%	30	60%
	Тийм	141	56%	28	56%	20	40%

ҮЗҮҮЛЭЛТ	ХАРИУЛТ	ИРГЭН		БАРИЛГЫН ЖИЖИГ ДУНД ААНБ		БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭГЧ	
		ТОО	ХУВЬ	ТОО	ХУВЬ	ТОО	ХУВЬ
А4. Танай байгууллага ААН дээр барилгын хог хаягдлыг дахин боловсруулахтай холбоотой ажлууд хэрхэн зохион байгуулагддаг вэ?	Үгүй	144	95%	44	88%	30	60%
	Тийм	7	5%	6	12%	20	40%
А5. Тийм бол та уг ажилд хэр идэвхтэй оролцдог вэ?	Огт оролцдоггүй	0	0%	0	0%	0	0%
	2	0	0%	0	0%	1	2%
	3	0	0%	0	0%	0	0%
	4	0	0%	1	17%	0	0%
	5	0	0%	0	0%	4	8%
	6	0	0%	0	0%	0	0%
	7	2	29%	2	33%	2	4%
	8	1	14%	0	0%	5	10%
	9	2	29%	1	17%	1	2%
	Маш сайн оролцдог	2	29%	2	33%	7	14%
А6.1. Барилгын хог хаягдлыг газар дор булаах нь зөв.	1 - Санал огт нийлэхгүй байна	128	51%	28	56%	15	30%
	2 - Санал нийлэхгүй байна	54	22%	11	22%	18	36%
	3 - Мэдэхгүй	11	4%	0	0%	5	10%
	4 - Санал нийлж байна	26	10%	4	8%	7	14%
	5 - Санал бүрэн нийлж байна	31	12%	7	14%	5	10%
А6.2. Барилгын дахин ашиглах боломжтой хог хаягдлыг булаахыг хориглох хэрэгтэй.	1 - Санал огт нийлэхгүй байна	8	3%	0	0%	3	6%
	2 - Санал нийлэхгүй байна	10	4%	3	6%	6	12%
	3 - Мэдэхгүй	4	2%	0	0%	1	2%
	4 - Санал нийлж байна	65	26%	8	16%	22	44%
	5 - Санал бүрэн нийлж байна	163	65%	39	78%	18	36%
А6.3. Барилгын хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах байдлыг нэмэгдүүлэх хэрэгтэй.	1 - Санал огт нийлэхгүй байна	1	0%	0	0%	1	2%
	2 - Санал нийлэхгүй байна	1	0%	0	0%	1	2%
	3 - Мэдэхгүй	1	0%	1	2%	0	0%
	4 - Санал нийлж байна	70	28%	5	10%	28	56%
	5 - Санал бүрэн нийлж байна	177	71%	44	88%	20	40%
А6.4. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн тоо, хүчин чадлыг нэмэгдүүлж, дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.	1 - Санал огт нийлэхгүй байна	0	0%	0	0%	0	0%
	2 - Санал нийлэхгүй байна	0	0%	0	0%	4	8%
	3 - Мэдэхгүй	1	0%	1	2%	1	2%
	4 - Санал нийлж байна	58	23%	3	6%	27	54%
	5 - Санал бүрэн нийлж байна	191	76%	46	92%	18	36%
А6.5. Монголд хог хаягдлыг устгах систем хангалтгүйгээс үүдэн байгаль орчин хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байна.	1 - Санал огт нийлэхгүй байна	2	1%	1	2%	2	4%
	2 - Санал нийлэхгүй байна	6	2%	2	4%	2	4%
	3 - Мэдэхгүй	1	0%	0	0%	1	2%
	4 - Санал нийлж байна	56	22%	5	10%	31	62%
	5 - Санал бүрэн нийлж байна	185	74%	42	84%	14	28%
А6.6. Барилгын хог хаягдлын менежментэд олон нийтийн анхаарал хяналтыг нэмэгдүүлэх хэрэгтэй.	1 - Санал огт нийлэхгүй байна	0	0%	0	0%	1	2%
	2 - Санал нийлэхгүй байна	3	1%	0	0%	1	2%
	3 - Мэдэхгүй	0	0%	0	0%	2	4%
	4 - Санал нийлж байна	64	26%	3	6%	31	62%
	5 - Санал бүрэн нийлж байна	183	73%	47	94%	15	30%

ҮЗҮҮЛЭЛТ	ХАРИУЛТ	ИРГЭН		БАРИЛГЫН ЖИЖИГ ДУНД ААНБ		БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭГЧ	
		ТОО	ХУВЬ	ТОО	ХУВЬ	ТОО	ХУВЬ
А6.7. Барилгын хог хаягдлын талаарх холбогдох хууль, дүрэм журмыг чангатгах хэрэгтэй.	1 - Санал огт нийлэхгүй байна	0	0%	0	0%	0	0%
	2 - Санал нийлэхгүй байна	4	2%	2	4%	1	2%
	3 - Мэдэхгүй	4	2%	0	0%	4	8%
	4 - Санал нийлж байна	57	23%	5	10%	30	60%
	5 - Санал бүрэн нийлж байна	185	74%	43	86%	15	30%
А6.8. Барилгын хог хаягдлын талаарх холбогдох хууль, дүрэм журмын хэрэгжилт, хяналтыг сайжруулах хэрэгтэй.	1 - Санал огт нийлэхгүй байна	1	0%	0	0%	0	0%
	2 - Санал нийлэхгүй байна	2	1%	0	0%	0	0%
	3 - Мэдэхгүй	1	0%	1	2%	1	2%
	4 - Санал нийлж байна	57	23%	6	12%	34	68%
	5 - Санал бүрэн нийлж байна	189	76%	43	86%	15	30%
А6.9. Барилгын салбарын ААНБ-ууд барилгын хог хаягдлын хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар хангалттай мэдлэг, мэдээлэлгүй.	1 - Санал огт нийлэхгүй байна	5	2%	0	0%	0	0%
	2 - Санал нийлэхгүй байна	7	3%	4	8%	4	8%
	3 - Мэдэхгүй	11	4%	0	0%	3	6%
	4 - Санал нийлж байна	72	29%	12	24%	28	56%
	5 - Санал бүрэн нийлж байна	155	62%	34	68%	15	30%
А6.10. Барилгын компани, туслан гүйцэтгэгч болон дахин боловсруулалт хийдэг ААНБ-ын уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй.	1 - Санал огт нийлэхгүй байна	0	0%	0	0%	1	2%
	2 - Санал нийлэхгүй байна	1	0%	0	0%	1	2%
	3 - Мэдэхгүй	2	1%	0	0%	2	4%
	4 - Санал нийлж байна	58	23%	9	18%	26	52%
	5 - Санал бүрэн нийлж байна	189	76%	41	82%	20	40%
А6.11. Барилгын хог хаягдлыг дахин боловсруулдаг үйлдвэр ААН Монгол улсад хангалттай бий.	1 - Санал огт нийлэхгүй байна	134	54%	23	46%	23	46%
	2 - Санал нийлэхгүй байна	75	30%	22	44%	15	30%
	3 - Мэдэхгүй	18	7%	1	2%	4	8%
	4 - Санал нийлж байна	11	4%	3	6%	5	10%
	5 - Санал бүрэн нийлж байна	12	5%	1	2%	3	6%
А6.12. Барилгын хатуу хог хаягдлыг булах төлбөрийг нэмэгдүүлснээр барилгын хог хаягдлыг газарт булдаг байдал буурна.	1 - Санал огт нийлэхгүй байна	15	6%	4	8%	7	14%
	2 - Санал нийлэхгүй байна	29	12%	13	26%	9	18%
	3 - Мэдэхгүй	14	6%	3	6%	4	8%
	4 - Санал нийлж байна	72	29%	17	34%	19	38%
	5 - Санал бүрэн нийлж байна	120	48%	13	26%	11	22%
А6.13. Барилгын дахин боловсруулсан материал нь дахин боловсруулаагүй материалтай харьцуулахад чанар нь ижилхэн.	1 - Санал огт нийлэхгүй байна	38	15%	2	4%	3	6%
	2 - Санал нийлэхгүй байна	56	22%	17	34%	15	30%
	3 - Мэдэхгүй	46	18%	4	8%	12	24%
	4 - Санал нийлж байна	66	26%	17	34%	13	26%
	5 - Санал бүрэн нийлж байна	44	18%	10	20%	7	14%

ҮЗҮҮЛЭЛТ	ХАРИУЛТ	ИРГЭН		БАРИЛГЫН ЖИЖИГ ДУНД ААНБ		БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭГЧ	
		ТОО	ХУВЬ	ТОО	ХУВЬ	ТОО	ХУВЬ
А7.1. Би хаа ч явсан хогоо ил задгай хаядаггүй.	1 - Хэзээ ч үгүй	53	21%	2	4%	24	48%
	2 - Ховор	10	4%	3	6%	2	4%
	3 - Заримдаа	28	11%	6	12%	1	2%
	4 - Голдуу	13	5%	3	6%	2	4%
	5 - Үргэлж	146	58%	36	72%	21	42%
А7.2. Ахуйн хэрэглээний хог хаягдлаа ангилж хаяхыг хичээдэг.	1 - Хэзээ ч үгүй	79	32%	16	32%	15	30%
	2 - Ховор	30	12%	5	10%	1	2%
	3 - Заримдаа	45	18%	8	16%	12	24%
	4 - Голдуу	43	17%	15	30%	9	18%
	5 - Үргэлж	53	21%	6	12%	13	26%
А7.3. /ААН-ээс асуух/ Дахин ашиглах боломжтой барилгын хог хаягдлыг хадгалан, дахин ашигладаг.	1 - Хэзээ ч үгүй	0	0%	50	100%	14	28%
	2 - Ховор	0	0%	0	0%	4	8%
	3 - Заримдаа	0	0%	0	0%	4	8%
	4 - Голдуу	0	0%	0	0%	5	10%
	5 - Үргэлж	0	0%	0	0%	23	46%
А7.4. /ААН-ээс асуух/ Барилгын хог хаягдлыг ангилан, дахин боловсруулах ажлыг гүйцэтгэхэд санхүүгийн асуудал тулгардаг.	1 - Хэзээ ч үгүй	0	0%	17	34%	15	30%
	2 - Ховор	0	0%	4	8%	1	2%
	3 - Заримдаа	0	0%	10	20%	12	24%
	4 - Голдуу	0	0%	2	4%	8	16%
	5 - Үргэлж	0	0%	17	34%	14	28%
А7.5. /ААН-ээс асуух/ Барилгыг хог хаягдал буулгалтын явцад ангилж ялгадаг.	1 - Хэзээ ч үгүй	0	0%	26	52%	18	36%
	2 - Ховор	0	0%	3	6%	7	14%
	3 - Заримдаа	0	0%	5	10%	5	10%
	4 - Голдуу	0	0%	7	14%	5	10%
	5 - Үргэлж	0	0%	9	18%	15	30%
А7.6. /ААН-ээс асуух/ Үр дүнтэй барилгын хог хаягдлын менежментийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг.	1 - Хэзээ ч үгүй	0	0%	19	38%	17	34%
	2 - Ховор	0	0%	5	10%	2	4%
	3 - Заримдаа	0	0%	6	12%	8	16%
	4 - Голдуу	0	0%	11	22%	7	14%
	5 - Үргэлж	0	0%	9	18%	16	32%

БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

3.1. МЭДЛЭГ МЭДЭЭЛЭЛ

“Монгол Улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих төсөл”-ийн талаар нийт иргэдийн 14 хувь нь сонсож байсан бол барилгын чиглэлийн ААНБ-ын 22 хувь нь, барилгын материал үйлдвэрлэгч ААН байгууллагын 20 хувь нь энэ талаар мэдээлэл сонсож байсан байна.

Төслийн талаар сонсож байсан иргэд ААН байгууллагын уг төслийн талаар хэр мэдлэг мэдээлэлтэй байгааг 1-10 хүртэлх оноогоор тодруулахад барилгын материал үйлдвэрлэгчид хамгийн өндөр буюу 5.4, иргэдийн хувьд мэдлэг нь 4.6 буюу барилгын материал үйлдвэрлэгч ААН байгууллагаас 0.8 оноогоор бага байна.


График 4. Барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих төслийн талаар сонсож байсан эсэх /Иргэн, ААН-ийн төрлөөр/



“Монгол Улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал цэвэр үйлдвэрлэлийн төсөл”-ийн талаар сонсож байсан иргэд болон ААН байгууллагаас уг төслийн талаарх мэдлэгийг 1-10 хүртэлх оноогоор 1 огт мэдэхгүй, 10 маш сайн мэднэ гэсэн байдлаар үнэлүүлсэн.

Төслийн талаар сонсож байсан иргэдийн 83 хувь нь уг төслийн талаар ямар нэгэн хэмжээгээр мэдээлэлтэй байна. Харин барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын 9 хувь нь уг төслийн талаар маш сайн мэдээлэлтэй байна.

График 5. Монгол Улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих төслийн талаарх мэдлэг /Иргэн, ААН-ийн төрлөөр/



Чанарын судалгааны үр дүнгээс 1: Барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих төслийн талаар сонсож байсан эсэх



"Уг төслийн талаар мэдээлэл маш багатай байна."

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын төлөөлөл

"Энэ төслийн талаар сонсож байгаагүй. Гэхдээ зурагтаар дахин боловсруулах үйлдвэрийн талаар мэдээлэл сонсож байсан."

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын төлөөлөл



"Энэ төслийн талаар сонсож байсан. Холбогдох хэд хэдэн гарын авлагуудыг уншиж байсан. Барилгын хог хаягдлын талаар холбогдох судалгаануудыг хийсэн байсан."

Барилгын салбарын төрийн байгууллагын төлөөлөл


Иргэн болон ААН байгууллагын хувьд сүүлийн жилүүдэд барилгын хог хаягдал маш ихээр нэмэгдэж байгаатай судалгаанд оролцсон иргэдийн 96 хувь нь санал нийлж байна.

Иргэдийн 38 хувь нь барилгын хог хаягдал сөрөг нөлөөлөл багатай гэсэн үзүүлэлттэй санал нийлж байгаа бол барилгын чиглэлийн жижиг, дунд ААН байгууллагууд 76 хувь буюу иргэдээс 2 дахин их хувиар санал нийлж байна.

ААН байгууллагын хувьд барилгын хог хаягдал боловсруулдаг ААН байгууллагын талаарх мэдээлэл муутай. Мөн энэ чиглэлийн үйлдвэр ААН байгууллагууд хангалтгүй байдаг гэж үзжээ.

Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах ангилан ялгах ажил Монгол улсад хангалттай хийгддэггүй, мөн холбогдох дүрэм журмын уялдаа холбоо болон хэрэгжилт хангалтгүй байна гэдэгтэй иргэн болон ААН байгууллагын хувьд 80-аас дээш хувь нь санал нийлсэн байна.

График 6. Барилгын салбарын хог хаягдлын талаарх хандлага /Иргэн, ААН-ийн төрлөөр/



ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГА ДАХЬ ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС:

Чанарын судалгааны үр дүнгээс 2:

Барилгын хог хаягдлын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх хандлага



"Байгаль орчинд нөлөөлөх барилгын хог хаягдал нь харьцангуй хүнсний болон гялгар уут бусад хогийг бодоход хор нөлөө багатай. Хуучин барилгуудаас гарч байгаа зарим хог хор нөлөө ихтэй. Шинэ барилгуудаас хор нөлөөтэй хог хаягдал гардаггүй."

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын төлөөлөл

"Тодорхой хэмжээний сөрөг нөлөө байгаа ба Цагаан давааны хогны цэгт хаядаг, будагны үнэр гэхээс өөр бусад материалын хувьд хүний бие, байгальд сөрөг нөлөө нь бага гэж бодож байна. Эмнэлгийн хог хаягдлаас бол хор бага ба бусад ахуйн хогтой адилхан. Гэхдээ айл өрхийн хог бол муудсан, муухай үнэртэй гэх мэт асуудалтай байдаг бол барилгын хог хаягдал нь муудах асуудал байхгүй."

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын төлөөлөл



"Мэдээж сөрөг нөлөөтэй. Энэ хог хаягдал өөрөө байгаль дээр устгахгүй. Цаас бол 50 жил, ундааны сав бол 200 жил гэдэгтэй адилхан, барилгын материалын хог хаягдал бол мөнхийн байж байдаг. Тийм учраас үүнийг дахин боловсруулах талын чиглэлээр бодлого боловсруулах ажил хийх нь зүйтэй гэж харагдаж байна."

Барилгын салбарын төрийн байгууллагын төлөөлөл

"Бусад хог хаягдал, хуванцар зэрэг хог хаягдалтай харьцуулбал химийн хор хөнөөл байхгүй. Байгалиас бүх түүхий эдийг ашиглаж байгаа учир эргээд байгальд шингэдэг гэж үзэж байна."

Барилгын салбарын төрийн байгууллагын төлөөлөл



Чанарын судалгааны үр дүнгээс 3:

Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах ажил хэр явагддаг гэж үздэг талаар



"Хог хаягдлаа мод, төмөр, бетон гэж гурав ангилдаг. Ахуйн хэрэглээний хог хаягдлаа тохижилт үйлчилгээний компаниар дамжуулан хаядаг. Модыг түлшинд, арматурыг төмрийн хаягдалд, бетоныг нэгдсэн хогны цэгт хаядаг. Эхний байдлаар ашиглах боломжтой бүтээгдэхүүнийг ашигладаг ч дахин боловсруулж ашиглах боломж бага гэж үздэг."

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын төлөөлөл

"Барилгын хог хаягдлаа ялгах ажил явагдахгүй байгаа. Хөөс, цонхны материал, арматур, чулуу шаврын хогийг заримдаа ялгадаг, бусад хог хаягдлыг бол ялгадаггүй."

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын төлөөлөл



"Монголд барилгын талбай дээрээс хог ангилан хаяж байгаа асуудал бол маш бага байдаг. Жишээ нь: Барилгын талбай дээрээс гарч байгаа хог хаягдлыг нэг хогийн саванд хийгээд хаядаг асуудал байгаа."

Барилгын салбарын төрийн байгууллагын төлөөлөл

"Явагдахгүй байна, муу байна. Барилгын хог хаягдлыг хамаагүй хаяж байна. Барилгын компаниуд тээврийн зардлаа хэмнээд энд тэнд нууцаар их хаяж байна. Дахин боловсруулах ажил маш хангалтгүй байна."

Барилгын салбарын төрийн байгууллагын төлөөлөл





"Барилгын хог хаягдлыг боловсруулах ажил хангалтгүй байна. Гэхдээ хичнээн сайн бодлого боловсруулаад явж байгаа ч гэсэн хяналт хангалтгүй болохоор ажлууд үр дүнгүй болдог."

Барилгын салбарын төрийн байгууллагын төлөөлөл

Чанарын судалгааны үр дүнгээс 4:

Барилгын хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүний талаарх мэдлэг болон туршлага

"Барилгын хог хаягдлаар дахин боловсруулсан бүтээгдэхүүн хэрэглэж үзээгүй болохоор сайн мэдэхгүй байна. Бүх стандарт, чанараа барьсан ба үнийн хувьд анхдагчаасаа хямд байвал дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг сонгоно."

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын төлөөлөл



"Дахин боловсруулсан бүтээгдэхүүн үйл ажиллагаандаа ашиглаж байгаагүй."

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын төлөөлөл

"Барилгын хог хаягдлаар ерөнхийдөө бүтээгдэхүүн хийдэггүй. Уруу газар тэгшлэхдээ тэндээ зөөж булаад дээр нь хөрс хийж байгаа болохоос биш яг барилгын хаягдлаар хийсэн юм байхгүй. Монголд дахин боловсруулсан бүтээгдэхүүнүүд чанарын шаардлага хангасан, стандартын дагуу бүтээгдэхүүн гардаггүй гэж үздэг. Шаардлага хангасан гэж батлагдвал авна."

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын төлөөлөл



Чанарын судалгааны үр дүнгээс 5:

Барилгын хог хаягдлыг устгах, ангилан ялгахад тулгардаг бэрхшээл



"Барилгын хог хаягдлыг ангилан ялгахад хүндрэлтэй. Барилгаас шавар, плита, чулуу, бетон, сав баглаа боодлын хаягдал гэх мэт гардаг. Дахин ашиглах боломжтой хог хаягдал байдаг ч ангилж ялгах, дахин боловсруулах үйлдвэр байдаггүй учир шууд хаягддаг. Ахуйн хог хаягдлууд шууд хаягддаг. Барилгаас гарсан хатуу шинж чанараа алддаггүй материалуудыг дүүргэлтэд ашигладаг."

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын төлөөлөл

"Асуудал гэвэл зөөж тээвэрлэе гэхээр хүнд даацын тусгай зориулалтын машин техник хэрэгтэй болдог. Энэ төрлийн хог хаягдлыг хүн дангаар ачих боломжгүй тусгай төхөөрөмжийн шанагаар хутгаж ачна. Энэ процесс зардал өндөртэй мөн хогийн цэг дээр дахиад зардал гардаг. Иймд барилгын салбарынхан хувийн жолооч нартай мөнгөөр тохироод тухайн хог хаягдлыг алга болгох ажлыг хийдэг. Энэ асуудлыг бол хууль эрхзүйгээ засч залруулна уу гэхээс биш энэ маягаараа явбал засагдахгүй."

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын төлөөлөл



"Нийслэлийн Мэргэжлийн Хяналт, Улаанбаатар хотын хүрээнд барилгын талбай дээрх талбайн зохион байгуулалттай холбоотой хяналт шалгалт бага явагддаг. Хүний нөөцийн дутагдал бас байдаг байх гэж боддог. Зарим тохиолдолд тухайн барилгаа дуусаж байхад нь хяналт очиж байх жишээтэй. Нийслэлийн нийтийн аж ахуй үйлчилгээний газраас ч гэсэн энэ талаар тодорхой хэмжээний хяналт хийгддэггүй. Хараа хяналтгүй байгаа тохиолдолд ангилан хаях асуудал бүрэн хэрэгжихгүй."

Барилгын салбарын төрийн байгууллагын төлөөлөл

Чанарын судалгааны үр дүнгээс 6: Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн талаар



"Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр Монгол улсад маш хангалтгүй байдаг. Үйлдвэр оруулж ирэх зардал өндөр, бусад улс оронтой харьцуулахад бага хаягдал гардаг, боловсруулж гаргаж ирсэн бүтээгдэхүүний борлуулалт муу байдаг."

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын төлөөлөл

"Барилгын хог хаягдлыг дахин боловсруулдаг ямар ААНБ-ууд байдаг талаар мэдээлэл байхгүй байдаг. Барилгын хог хаягдлаа өөрсдөө ангилан ялгахад хүндрэлтэй байдаг."

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын төлөөлөл



Чанарын судалгааны үр дүнгээс 7:

Барилгын хог хаягдлын талаарх холбогдох хууль журам, хэрэгжилтийн талаар



"Барилгын хог хаягдлын талаарх холбогдох хууль журмын талаар хангалттай мэдээлэлгүй байна."

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын төлөөлөл

"Хогоо хаях ёстой газраа аваачиж хаядаг. Ямар журам байдаг талаар мэдээлэл байдаггүй."

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын төлөөлөл



"ААН-үүд дээр хог хаягдлыг яаж ангилах тодорхой журамтай болгоод түүнд хүрэх эдийн засагтай нь холбоод өгвөл журам мөрдөгдөх байх гэж бодож байна. Нэг барилга буулгах, нэг барилга барихад хог гарч байгаа тэрийг хогийн цэг рүү хүргэхэд тухайн үйлдвэр нь ялгаад авчихдаг эерэг байдлаар ашиглавал үр дүнд хүрнэ."

Барилгын салбарын төрийн байгууллагын төлөөлөл

"Барилгын тухай хуулиа дагаад хогтой холбоотой тодорхой зохицуулалт манай хуульд байхгүй. Гэхдээ барилга байгууламж угсралтын үйл ажиллагаа явуулж байхад мөрдөх дүрэм журам, заавар, аргачлалыг батлаад өгсөн байдаг. Үүний дагуу үйл ажиллагаагаа явуулдаг."

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын төлөөлөл




3.2. ХАНДЛАГА ЗУРШИЛ


Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагуудын 12 хувьд нь барилгын хог хаягдал дахин боловсруулахтай холбоотой ажлууд ямар нэгэн байдлаар зохион байгуулагдаж байсан бол барилгын материал үйлдвэрлэгч ААН байгууллагуудын 40 хувьд нь барилгын хог хаягдлыг дахин боловсруулахтай холбоотой ажил зохион байгуулагдаж байсан байна.

График 7. Барилгын хог хаягдлыг боловсруулах, ашиглахтай холбоотой сургалт зохион байгуулагдаж байсан эсэх /ААН-ийн төрлөөр/

Барилгын салбарын жижиг дунд ААНБ




Барилгын материал үйлдвэрлэгч ААНБ



Барилгын хог хаягдлыг газарт булах нь буруу гэж иргэдийн 73 хувь нь үзэж байгаа бол барилгын салбарын ААН байгууллагын 78 хувь нь, барилгын материал үйлдвэрлэгч ААН байгууллагын 66 хувь нь буруу гэж үзэж байна.

График 8. Барилгын хог хаягдлыг газарт булж байгаа талаарх нийтийн хандлага /Иргэд, ААН-ийн төрлөөр/


Барилгын хог хаягдлыг газар дор булах нь зөв



Иргэд болон ААН байгууллагуудын 80-аас дээш хувь нь Барилгын дахин ашиглах боломжтой хог хаягдлыг булахыг хориглох нь зүйтэй гэж үзжээ.

График 9. Барилгын дахин ашиглах боломжтой хог хаягдлыг булахыг хориглох хэрэгтэй эсэх /иргэд, ААН-ийн төрлөөр/


Барилгын дахин ашиглах боломжтой хог хаягдлыг булахыг хориглох хэрэгтэй



Барилгын хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах байдлыг нэмэгдүүлэх хэрэгтэй гэж иргэдийн 99 хувь нь үзэж байна.

График 10. Барилгын хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах байдлыг нэмэгдүүлэх хэрэгцээ /иргэд, ААН-ийн төрлөөр/

Барилгын хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах байдлыг нэмэгдүүлэх хэрэгтэй.



Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагууд Монголд хог хаягдал устгах систем хангалтгүйгээс үүдэн байгаль орчин хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байна гэдэгтэй 84 хувь нь санал нийлж байна.

График 11. Монголд хог хаягдлыг устгах систем хангалтгүйгээс үүдэн байгаль орчин хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж буй талаарх хандлага /иргэд, ААН-ийн төрлөөр/


Монголд хог хаягдлыг устгах систем хангалтгүйгээс үүдэн, байгаль орчин хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байна.



Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын хувьд барилгын хог хаягдлын менежментэд олон нийтийн анхаарал хяналтыг нэмэгдүүлэх хэрэгтэй гэсэн үзүүлэлтэд 100 хувь санал нийлсэн байна.

График 12. Барилгын хог хаягдлын менежментэд олон нийтийн анхаарал хяналтыг нэмэгдүүлэх хэрэгтэй гэдэгтэй санал нийлж буй байдал /иргэд, ААН-ийн төрлөөр/

Барилгын хог хаягдлын менежментэд олон нийтийн анхаарал хяналтыг нэмэгдүүлэх хэрэгтэй.



Барилгын хог хаягдлын талаарх холбогдох хууль, дүрэм журмын хэрэгжилт, хяналтыг сайжруулах хэрэгтэй гэж иргэдийн 99 хувь нь үзэж байгаа бол барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын 98 хувь нь санал нийлжээ.

График 13. Барилгын хог хаягдлын талаарх холбогдох хууль, дүрэм журмын хэрэгжилт хяналтыг сайжруулах талаар /иргэд, ААН-ийн төрлөөр/


Барилгын хог хаягдлын талаарх холбогдох хууль, дүрэм журмыг хэрэгжилт, хяналтыг сайжруулах хэрэгтэй



Барилгын хог хаягдлын хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар иргэд болон барилгын салбарын жижиг дунд ААН байгууллага, барилгын материал үйлдвэрлэгч ААНБ-уудад мэдлэг мэдээлэл маш хангалтгүй байна.

График 14. Барилгын салбарын ААН байгууллагын барилгын хог хаягдлын хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн талаар хангалттай мэдлэг мэдээлэлтэй эсэх /иргэд, ААН-ийн төрлөөр/

Барилгын салбарын ААНБ-ууд барилгын хог хаягдлын хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар хангалттай мэдлэг, мэдээлэлгүй.



Барилгын компани, туслан гүйцэтгэгч болон дахин боловсруулалт хийдэг ААН байгууллагын уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй гэдэгт иргэд болон ААН байгууллагуудын 90 болон түүнээс дээш хувь нь санал нийлж байгаа нь барилгын компани, туслан гүйцэтгэгч дахин боловсруулалт хийдэг ААН байгууллагын хоорондын уялдаа холбоо маш хангалтгүй байгааг харуулж байна.

График 15. Барилгын компани, туслан гүйцэтгэгч болон дахин боловсруулалт хийдэг ААНБ-ын уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй эсэх /иргэд, ААН-ийн төрлөөр/


Барилгын компани, туслан гүйцэтгэгч болон дахин боловсруулалт хийдэг ААНБ-ын уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй.



Монгол улсад барилгын хог хаягдлыг дахин боловсруулдаг үйлдвэр ААН байгууллага тун хангалтгүй байна.


График 16. Барилгын хог хаягдлыг дахин боловсруулдаг үйлдвэр ААН Монгол улсад хангалттай байгаа гэдэгтэй санал нийлж буй байдал /иргэд, ААН-ийн төрлөөр

Барилгын хог хаягдлыг дахин боловсруулдаг үйлдвэр ААН Монгол улсад хангалттай бий.




Барилгын хатуу хог хаягдлыг булах төлбөрийг нэмэгдүүлснээр барилгын хог хаягдлыг газарт булдаг байдал буурна гэж иргэдийн 77 хувь нь үзэж байгаа бол барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын 34 хувь нь энэ үзүүлэлттэй санал нийлэхгүй гэсэн байна.

График 17. Барилгын хатуу хог хаягдлыг булах төлбөрийг нэмэгдүүлснээр барилгын хог хаягдлыг газарт булдаг байдал буурна гэдэгтэй санал нийлж буй байдал



Барилгын дахин боловсруулсан материал нь дахин боловсруулаагүй материалтай чанар нь ижилхэн гэж барилгын материал үйлдвэрлэгч ААН байгууллагын 40 хувь, барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын 54 хувь нь чанар нь дахин боловсруулаагүй материалтай харьцуулахад ижил гэж үзэж байна.

График 18. Барилгын дахин боловсруулсан материал нь дахин боловсруулаагүй материалтай харьцуулахад чанар нь ижил гэдэгтэй санал нийлж буй байдал /иргэд, ААН-ийн төрлөөр/




Судалгаанд хамрагдсан иргэдийн 58 хувь нь хогоо ил задгай хаядаггүй байна. Харин ахуйн хэрэглээний хогоо ангилж ялгах тухайд бол иргэдийн 21 хувь нь хогоо үргэлж ангилж ялгахыг хичээдэг байна.

График 19. Иргэдийн хандлага

Би хаа ч явсан хогоо ил задгай хаядаггүй /Иргэд/



Ахуйн хэрэглээний хог хаягдлаа ангилж хаяхыг хичээдэг /Иргэд/



Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын 48 хувь нь үйл ажиллагаандаа үр дүнтэй барилгын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлдэггүй бөгөөд барилгын хог хаягдал буулгалтын явцад нийт ААН-үүдийн 58 хувь нь барилга буулгалтын явцад гарсан хог хаягдлаа ангилж ялгадаггүй байна. Дахин ашиглах боломжтой барилгын хог хаягдлыг хадгалан, дахин ашигладаг ААН байгууллага байхгүй байна.

График 20. Барилгын хог хаягдлын талаарх барилгын салбарын жижиг дунд ААНБ-ын хандлага

Барилгын материал үйлдвэрлэгч ААНБ



Барилгын материал үйлдвэрлэгч байгууллагуудын 46 хувь нь үр дүнтэй барилгын хог хаягдлын менежментийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг байна. Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах ангилахад нийт барилгын материал үйлдвэрлэгч ААН байгууллагуудын 68 хувьд нь санхүүгийн асуудал тулгардаг байна. Дахин ашиглах боломжтой барилгын хог хаягдлыг хадгалан, дахин ашигладаг байдал 50 хувьтай байна.

График 21. Барилгын хог хаягдлын талаарх барилгын материал үйлдвэрлэгч ААНБ-ын хандлага



3.3. МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЦЭЭ

Барилгын салбарын жижиг дунд болон барилгын материал үйлдвэрлэгч ААН байгууллагад барилгын хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүний талаар болон хог хаягдлын менежментийн талаар мэдээлэл 10-н ААН байгууллагын 9-д нь хэрэгцээтэй байна.

График 22. Барилгын хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүн болон барилгын хог хаягдлын менежментийн талаар мэдээллийн хэрэгцээ /Иргэн, ААН-ийн төрлөөр/



Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагуудын хувьд барилгын хог хаягдал дахин боловсруулах боломж, барилгын хог хаягдал дахин ангилах бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаар мэдээлэл хамгийн хэрэгцээтэй байна.

График 23. Барилгын хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүн болон барилгын хог хаягдлын менежментийн талаарх хэрэгцээтэй мэдээлэл /Иргэн, ААН-ийн төрлөөр/



Барилгын хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүн болон барилгын хог хаягдлын менежментийн талаар хэрэгцээтэй мэдээллээ цахим дижитал контент болон ТВ нэвтрүүлэг хэлбэрээр хүлээн авах нь илүү үр дүнтэй байна.


График 24. Барилгын хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүн болон барилгын хог хаягдлын менежментийн талаар мэдээлэл авах сонирхол /Иргэн, ААН-ийн төрлөөр/



3.4. МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ХЭРЭГЛЭЭ

MNB сувгийг нийт телевиз үздэг оролцогчдын 66 хувь нь буюу хамгийн их хувь нь сонгож үздэг бөгөөд дараагаар нь Боловсрол телевиз, Монгол телевизийг ихэвчлэн үздэг гэжээ.

График 25. Ихэвчлэн үздэг телевизийн суваг



Телевиз үздэг оролцогчдын хувьд цаг үеийн мэдээний нэвтрүүлгийг хамгийн их буюу 86.6 хувь нь үздэг байна. Түүнчлэн танин мэдэхүйн болон, баримтат олон ангит киног ихэвчлэн үздэг байна.


График 26. Телевизээс голчлон үздэг нэвтрүүлгийн төрөл

Ихэвчлэн үздэг суваг




Телевизийг ихэнхдээ оройн цагаар үздэг бөгөөд 50-с дээш хувь нь өдөрт 3-аас дээш цаг зурагт үздэг байна.

График 27. Телевиз үздэг тогтмол цаг болон үргэлжлэх хугацаа



ФМ сонсдог оролцогчдын хувьд гэр бүлийн радио 104.5 болон шинэ долгион 107.5 ФМ радиог хамгийн их сонсдог байна.

График 28. Ихэвчлэн сонсдог ФМ радио



ФМ радиогийн дууны төрлийн нэвтрүүлгийг хамгийн их сонсдог байна.

График 29. ФМ радиогоос сонсдог нэвтрүүлгийн төрөл

Ихэвчлэн сонсдог нэвтрүүлгийн төрөл





ФМ радиог үдээс өмнө буюу 7-12 цагийн хооронд ихэвчлэн сонсдог байна.

График 30. ФМ сонсдог тогтмол цаг болон үргэлжлэх хугацаа


ФМ сонсдог цаг

ФМ сонсохдоо зарцуулдаг хугацаа



Сонин уншдаг оролцогчдын хувьд өдрийн сониныг хамгийн их уншдаг байна.

График 31. Ихэвчлэн уншдаг, сонин сэтгүүл



Сонин сэтгүүл уншдаг оролцогчдын хувьд цаг үеийн мэдээлэл, цаг агаар, зах зээл эдийн засагтай холбоотой мэдээллийг ихэвчлэн уншдаг байна.


График 32. Сонин сэтгүүлээс ихэвчлэн уншдаг мэдээний төрөл

Сонин, сэтгүүлээс ихэвчлэн уншдаг мэдээний төрөл



Интернэт ашигладаг оролцогчдын 34.7 хувь нь gogo.mn, 29.5 хувь нь ikon.mn веб хуудсыг ашигладаг байна.


График 33. Ихэвчлэн ашигладаг веб хуудас



Вебсайтаас цаг үеийн мэдээ, эрүүл мэндтэй холбоотой мэдээллүүдийг ихэвчлэн уншдаг байна.

График 34. Вэб сайтаас уншдаг мэдээний төрөл

Вэб сайтаас ихэвчлэн уншдаг мэдээний төрөл



Нийт судалгаанд оролцогчдын 96.9 хувь нь Фейсбүүк ашигладаг бол 16 хувь нь Инстаграмм сүлжээг ашигладаг байна.

График 35. Ихэвчлэн ашигладаг сошиал хуудас



Сошиал сүлжээнээс цаг үеийн мэдээ болон эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг ихэвчлэн уншдаг байна.

График 36. Сошиал сүлжээнээс уншдаг мэдээний төрөл

Сошиал сүлжээнээс ихэвчлэн уншдаг мэдээний төрөл



БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ

Сүүлийн жилүүдэд барилгын салбар өргөжин тэлж үүнийг дагаад барилгын хог хаягдал нэмэгдэж байна гэдэгтэй иргэд болон ААН байгууллагууд бүрэн санал нэгдэж байна.

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагуудын хувьд барилгын хог хаягдал нь хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл багатай гэдэгтэй санал нэгдэж байгаа нь барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагын 76 хувь, барилгын материал үйлдвэрлэгчдийн 56 хувь нь санал нэгдэж байгааг харахад энэ талын мэдээлэл дутмаг байгааг илтгэж байна.

Барилгаас гарч буй хог хаягдлыг дахин ашиглах боломж өндөр байдаг гэдэгтэй барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагуудын 72 хувь нь, барилгын материал үйлдвэрлэгч ААН байгууллагын 82 хувь нь санал нэгдэж байна. Мөн барилгын ямар төрлийн хог хаягдал нь дахин ашиглагдах боломжтой талаар барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагуудын 80 хувь нь, барилгын материал үйлдвэрлэгч ААН байгууллагуудын 74 хувь нь мэднэ гэж үзэж байна. Мөн барилгын хог хаягдлыг дахин боловсруулдаг үйлдвэр байхгүй гэдэгтэй иргэдийн 87 хувь нь, барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагуудын 84 нь санал нийлж байна.

Барилгын салбарын жижиг дунд ААН болон барилгын материал үйлдвэрлэгч ААН байгууллагуудын хувьд барилгын хог хаягдал дахин ашиглах боломж өндөртэй, ямар төрлийн хог хаягдал нь дахин ашиглагдах боломжтой талаар харьцангуй мэдээлэлтэй байгаа хэдий ч барилгын хог хаягдлыг ямар үйлдвэр, ААН байгууллагууд дахин боловсруулалт хийдэг, эдгээр байгууллага үйлдвэрүүдтэй хэрхэн холбогдох талаар мэдээлэлгүй байна. Мөн барилгын дахин боловсруулсан бүтээгдэхүүний чанарт бүрэн дүүрэн итгэхгүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Дахин боловсруулсан барилгын бүтээгдэхүүн нь ижил төрлийн бүтээгдэхүүнтэй харьцуулахад адил чанартай нь нотлогдсон, мөн илүү өртөг багатай бол уг бүтээгдэхүүнийг сонгон үйл ажиллагаандаа хэрэглэх боломжтой гэж үзсэн байсан.

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах ЗР аргачлалын талаар барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагуудын 28 хувь нь сонсож байсан байна.

Барилгын дахин ашиглах боломжтой хог хаягдлыг булахыг хориглох хэрэгтэй гэдэгтэй иргэдийн 91 хувь, барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагуудын 94 хувь, барилгын материал үйлдвэрлэгч байгууллагуудын 80 хувь нь санал нэгдэж байна.

Иргэн болон барилгын салбарын ААН байгууллага болон барилгын материал үйлдвэрлэгчдийн хувьд барилгын хог хаягдалтай холбогдох хууль, журмын талаар хангалттай мэдээлэлгүй байгаа бөгөөд холбогдох хууль журмын хэрэгжилт бодит байдал дээр маш тааруу байна гэж үзжээ. Барилгын ажил гүйцэтгэж буй ААН байгууллагуудад тодорхой хяналт шалгалтыг тогтмол хийж, олон нийтийн хяналтыг мөн нэмэгдүүлэх хэрэгтэй гэж үзсэн байна.

Барилгын салбарын ААН байгууллагын 52 хувь нь үр дүнтэй барилгын хог хаягдлын менежментийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг бөгөөд барилгын хог хаягдлыг ангилан ялгахад 58 хувьд нь санхүүгийн асуудал тулгардаг. Харин барилгын материал үйлдвэрлэгч ААН байгууллагуудын 62 хувь нь үр дүнтэй барилгын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлдэг бөгөөд 68 хувьд нь барилгын хог хаягдлаа ангилан ялгахад санхүүгийн асуудал тулгардаг байна.

Барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагуудын хувьд барилгын хог хаягдлаа ангилан ялгах нь зардал өндөртэй, ажиллагаа ихтэй, ангилж ялгалаа гэхэд хаана хандахаа мэдэхгүй байдаг тул хогийн цэг дээр аваачиж хаях, хатуу хог хаягдлыг барилгын суурь дүүргэлтэд хийх, ачааны машинтай жолооч нартай тохиролцон хогоо зайлуулах зэрэг аргаар устгаж байна. Тиймээс барилгын салбарын жижиг дунд ААН байгууллага, барилгын материал үйлдвэрлэгч ААН байгууллагуудад барилгын материал дахин боловсруулдаг үйлдвэр ААН байгууллагыг сурталчлан таниулах, хамтын ажиллагааг өргөжүүлэн, уялдаа холбоогоо сайжруулах хэрэгтэй байна.

Барилгын хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүн болон барилгын хог хаягдлын менежментийн талаарх мэдээлэл барилгын салбарын жижиг дунд ААН байгууллагуудын 90 хувьд нь, барилгын материал үйлдвэрлэгч ААН байгууллагын 88 хувьд нь хэрэгцээтэй байна.

Барилгын салбарын жижиг дунд болон барилгын материалын үйлдвэрлэгч ААН байгууллагад барилгын хог хаягдал дахин боловсруулах боломж болон барилгын хог хаягдал дахин ангилж ялгах, барилгын хог хаягдлын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаар мэдээлэл илүү хэрэгцээтэй байна. Энэ төрлийн мэдээллийг цахим, дижитал контент болон телевизийн нэвтрүүлэг хэлбэрээр авбал илүү өгөөжтэй гэж үзжээ.

Байгууллагад барилгын хог хаягдал дахин боловсруулах боломж болон барилгын хог хаягдал дахин ангилж ялгах, барилгын хог хаягдлын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаар хамгийн их ашиглаж буй мэдээллийн эх үүсвэр болох телевиз, сошиал сүлжээ, мэдээний сайт, болон ФМ радио ашиглавал тодорхой үр дүнд хүрнэ гэж үзэж байна.

Телевизийн хувьд Монголын үндэсний олон нийтийн радио телевиз, Боловсрол суваг, Монгол ТВ, ТВ-9 сувгийг хамгийн их үздэг бөгөөд оройн 18 цагаас хойш телевиз үзэх хандлага хамгийн өндөр байна. Телевизээр цаг үеийн мэдээ болон танин мэдэхүйн нэвтрүүлэг, олон ангит киног хамгийн ихээр үзэж байгаа бөгөөд уг нэвтрүүлгүүдийн дундуур барилгын хог хаягдал түүнтэй холбоотой мэдээллийг хүргэх нь зүйтэй юм.

Сошиал сүлжээний хувьд Фейсбүүк сүлжээг нийт судалгаанд хамрагдсан оролцогчдын 97 хувь нь ашиглаж байгаа бөгөөд Фейсбүүк хуудсаар барилгын хог хаягдал дахин боловсруулах боломж, барилгын хог хаягдлын бүтээгдэхүүний талаарх мэдээллийг дижитал контент видео, сонирхолтой инфографик хэлбэрээр хүргэх хэрэгтэй.

Веб хуудасны хувьд gogo.mn хуудсыг 34.7 хувь, ikon.mn хуудсыг 29.5 хувь, news.mn хуудсыг 24.2 хувь нь ашигладаг.

ФМ радио сонсдог сонсогчдын хувьд Гэр бүлийн радио 104.5, Шинэ долгион 107.5 ФМ радиог хамгийн их сонсдог бөгөөд үдээс өмнөх буюу 7-12 цагийн хооронд хамгийн их ФМ радиог сонсдог байна. ФМ-ээр ихэвчлэн дууны нэвтрүүлэг болон цаг үеийн мэдээтэй холбоотой мэдээллийг хамгийн их сонсдог гэжээ. Тиймээс эдгээр цагуудаар барилгын хог хаягдал түүнтэй холбоотой мэдээ мэдээллийг хүргэх нь үр дүнтэй байна.

КАРИТАС ЧЕХ РИПАБЛИК
2019 он

